





МЕГА ТӨСЛИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ


Монголбанкны эрдэм шинжилгээний хуралд зориулав.

Гүйцэтгэсэн: Б. Баярхүслэн
Удирдсан: Б. Лхагважаргал





1. Судалгааны үндэслэл
2. Судлагдсан байдал
3. Онолын хэсэг
4. Шинжилгээний хэсэг
5. Дүгнэлт, санал зөвлөмж



СУДАЛГААНЫ АСУУДАЛ

Үндэслэл


Монгол Улсын 2024 онд хамтарсан ЗГ байгуулагдаж, 2028 он хүртэл бүрэн эрхийнхээ хугацаанд, улсын **эдийн засгийн суурийг тэлэх** эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн хөгжлийн томоохон 14 мега төслүүдийг хэрэгжүүлэхээр болсон.

Зорилго

Монгол Улсад мега төсөл хэрэгжиж, **ГШХО-ын эерэг шок бий болсон нөхцөлд** макро эдийн засгийн гол хувьсагчдад хэрхэн нөлөөлж байгааг Мунделл–Флемингийн жижиг, нээлттэй эдийн засгийн онолын загварт тулгуурлан шинжлэв.

Таамаглалууд

1. ГШХО орж ирснээр эдийн засагт өсөлт бий болгож, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
 - ❖ Оюу Толгойн төсөл орон нутгийн эдийн засагт бодитой хувь нэмэр оруулж, ДНБ-ийг 9.4 хувиар өсгөж, 28 мянган ажлын байр шинээр бий болгосон. (МУИС ЭЗХ, 2018)
2. ГШХО огцом нэмэгдсэнээр Голланд өвчин (Corden, 1982) бий болох эрсдэлтэй.
 - ❖ Эдийн засагт их хэмжээний валютын урсгал орж ирэх үед дотоодын валют чангарч, бусад экспортод чиглэсэн салбаруудын өрсөлдөх чадвар буурах үзэгдэл



СУДЛАГДСАН БАЙДАЛ

01

Ган-Очир, Даваажаргал (2017) Гадаад шок-МУ-ын эдийн засгийн 55% Эдгээр шокуудыг салбар, хэрэглээ, хөрөнгө оруулалт, экспорт, импорт зэрэг бүрдэл хэсгүүд дээр задлан шинжлэх нь зүйтэй хэмээн санал болгосон.

03

BVAR загварыг оновчтой ашиглах арга зүйг Литтерман (1986) анх боловсруулсан бөгөөд Minnesota prior ашиглан параметрийн агшилтыг (shrinkage) оновчтой тохируулах замаар overfitting-ийг бууруулж, таамалалын гүйцэтгэлийг сайжруулах боломжтойг харуулсан

05

Б.С. Фишер, Stanley Fischer, Б. Жапгалсайхан нарын тооцооллоор Оюу Толгой төсөл ДНБ-ийг ойролцоогоор 36 %-иар өсгөх ч төгрөгийн ханш чангарснаар уул уурхайн бус салбаруудын өрсөлдөх чадвар сулрах эрсдэлтэй.

02

Д. Даваадулам (2018) ГХО-н төвлөрлийг Херфиндаль-Хиршманы индексээр хэмжихэд МУ уул уурхайгаас хэт хамааралтай байгааг дахин баталсан бөгөөд энэ байдлыг өөрчлөхийн тулд салбарын төрөлжилтийг дэмжих бодлого шаардлагатайг онцолжээ.

04

Ц. Бямбацогт, Д. Цэнддорж (2018) нарын судалгаагаар нефть, төмөр зам, эрчим хүчний төслүүд эдийн засгийн бүтцийг өргөжүүлдэг бол уул уурхайн олборлолтын төсөл харьцангуй бага өсөлт авчрах магадлалтайг харуулсан.

06

А. Ананд (2011) гадаадын шууд хөрөнгө оруулалт нийт эдийн засагт эерэг нөлөөтэй ч уул уурхай, барилгын салбарт сөрөг үр дагавар үүсгэсэн.







ОНОЛЫН ХЭСЭГ

Мунделл-Флимингийн жижиг нээлттэй эдийн засгийн загвар

ХӨВӨГЧ ХАНШИЙН ТОГТОЛЦООТОЙ ҮЕД				
Загварын хувьсагчдад үзүүлэх нөлөө				
БОДЛОГЫН ХЭЛБЭР\ХУВЬСАГЧИД		Үйлдвэрлэл	Ханш	Цэвэр экспорт
САНГИЙН БОДЛОГО	ТЭЛЭХ	0	↑	↓
МӨНГӨНИЙ БОДЛОГО	ЗӨӨЛӨН	↑	↓	↑







ОНОЛЫН ХЭСЭГ


IS муруй: $Y = C(Y - T) + I(r) + G + NX$

LM муруй: $\frac{M}{P} = L(r, Y)$

BP муруй: $CA + KA = 0$




ТӨЛӨВ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ




ТӨЛӨВ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

ХАА, Уул уурхай, Бөөний худалдааны салбарууд
ДНБ-н дийлэнх хэсгийг бүрдүүлж байна.



ГШХО ихээр орж ирэхэд улсын төсөв дагаад
тэлсэн байна.



VAR

VAR загварын ерөнхий тавил:

$$Y_t = c + A_1 Y_{t-1} + \dots + A_p Y_{t-p} + u_t$$

VAR загвар хувьсагчдын тоог 3–10 орчимд бага байлгаж, параметрийн тоог хязгаарлах нь түгээмэл байдаг. (үнийн оньсого)

Нэгж язгуурын арга:

Dickey-Fuller test

X-13 улирал засварлах арга


Нормаль
урвуу 'Wishart'
приор


BVAR

Ковариацийн матриц нь $E(u_t u_t') = \Psi$
Litterman (1986a) Minnesota приорыг санал болгосон бөгөөд үндсэн санаа нь VAR-ын тэгшитгэлүүд сул гишүүнтэй 'random walk' процессын орчим төвлөрнө гэдэг суурилдаг:

$$Y_t = c + A_1 Y_{t-1} + \dots + A_p Y_{t-p} + u_t, \quad A_1 = I$$

- $E[(A_k)_{ij}] = \begin{cases} \delta_{ij}, & j = i, p = 1 \\ 0, & \text{бусад үед} \end{cases}$
- $V[(A_k)_{ij}] = \begin{cases} \frac{\lambda^2}{p^2}, & j = i \\ \vartheta \frac{\lambda^2 \sigma_i^2}{p^2 \sigma_j^2}, & \text{бусад үед} \end{cases}$





ХУВЬСАГЧИД



01

Экзоген хувьсагч



Мега төсөл хөтөлбөр→ГШХО-аар орж ирсэн



02

ДНБ ба бүрэлдэхүүн салбаруудын хувьсагчид



Бодит ДНБ, ХАА, Уул уурхай, Боловсруулах, Эрчим хүч, Барилга, Худалдаа, Тээвэр, Мэдээлэл холбоо, Бусад



03

Мөнгөний бодлогын үндсэн хувьсагчид



ХҮИ, Мөнгөний нийлүүлэлт, Бодлогын хүү, Зээлийн хүү



04



Сангийн болон ХЗЗ-ийн хувьсагчид

Төсвийн зардал, Татварын орлого, Цалин, Ажилгүйдлийн түвшин



05




Гадаад секторын хувьсагчид

ГШХО, Цэвэр экспорт, NEER



ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭСЭГ

Хариу үйлдлийн функц: БДНБ ба салбаруудаар




Өссөн салбарууд

БДНБ
Уул уурхай
Эрчим хүч
Худалдаа
Мэдээлэл холбоо
Бусад



ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭСЭГ

Хариу үйлдлийн функц: БДНБ ба салбаруудаар




Буурсан салбарууд

ХАА
Боловсруулах
Барилга
Тээвэр



ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭСЭГ

Хариу үйлдлийн функц: Мөнгөний бодлогын үндсэн хувьсагчдын нөлөө




ХҮИ тасралтгүй өсч, 13-р улирлаас мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлж эхэлж байна.

Бодлогын хүү, зээлийн хүүний динамик ижил хариу үйлдэл үзүүлсэн.



ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭСЭГ

Хариу үйлдлийн функц: Гадаад сектор, Төсөв, ХЗЗ



Гадаад сектор: Цэвэр экспорт
тогтмол сөрөг-импорт хамаарал
их
NEER ханш чангарсан

Төсөв: Зардлын тэлэлт
Татварын орлого өссөн

Хөдөлмөрийн зах зээл:
Цалингийн өсөлт
Ажилгүйдлийн түвшин буурсан




Жижиг нээлттэй эдийн засагтай манай орны хувьд мега төсөл хэрэгжсэнээр (ГШХО эерэг шок) богино хугацаанд бодит ДНБ-ийг 1–2%-иар өсгөж, худалдаа, мэдээлэл холбоо, эрчим хүч зэрэг салбарууд өсөлттэй хариу үзүүлэв. Харин хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбарууд валютын ханшийн чангарлаас үүдэн өрсөлдөх чадвараа алдаж “Голланд өвчин” ажиглагдсан.

Хэрэглээний үнийн индекс тасралтгүй өсч, бодлогын хүү, зээлийн хүү нэмэгдэх нь инфляцын дарамт нэмэгдэж буйг илтгэж, зээлийн өртөгт дарамт үзүүлж буйг харуулав. Цэвэр экспорт тогтмол сөрөг хандлагатай байсан нь импортын өндөр хамаарал, дотоодын үйлдвэрлэлийн сул экспортын илрэл юм.

Томоохон төсөл хөтөлбөр хэрэгжсэнээр ажлын байр нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулсан нь хөдөлмөрийн зах зээлд эерэг дамжих сувгаар нөлөөлж буйг харууллаа.

Мега төсөл ГШХО-аар дамжин богино хугацаанд макро эдийн засгийн өсөлтийг дэмжих хүчтэй нөлөөтэй ч, инфляц, төлбөрийн тэнцэл, валютын ханш, зээлийн өртөг зэрэг суурь үзүүлэлтүүдэд дунд болон урт хугацааны дарамт бий болгох магадлал өндөр байна. Төсөл хөтөлбөр зөвхөн ГШХО-ын санхүүжилтаар орж ирэхгүй бөгөөд (ТХХТ, ТӨК, зээл г.м) төслүүдийн дэлгэрэнгүй өгөгдөл байгаа үед энэхүү судалгааны ажлыг бусад санхүүжилтийн хэлбэрээр төслийн нөлөөг тооцож сайжруулах боломжтой.




САНАЛ ЗӨВЛӨМЖ

Салбарын төрөлжилт болон экспортын өрсөлдөх чадварыг сайжруулах.

Дурдсан салбарууд ГШХО-ын үр өгөөжийг шууд хүртэх боломжгүй байгааг харгалзан үзвэл, төрийн зүгээс салбарын төрөлжилтийг дэмжсэн, **нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийн бүтцийг хөгжүүлэх** бодлого хэрэгжүүлэх шаардлага үүсч байна. Мөн ханшийн чангарлаас үүдэлтэй экспортын өрсөлдөх чадварыг бууруулж байгаа үеп төв банк валют худалдан авч, төгрөгийг нийлүүлэх замаар үйлдвэрлэл, ажил эрхлэлтэд сөрөг нөлөөгүй байдлаар ханшийг бууруулах интервенц хийх хэрэгтэй.

Уул уурхайн орлогыг баялгийн санд төвлөрүүлэх


ГШХО-ын орлогоос үүдэж төсвийн зардлыг өсгөхөөс зайлсхийж, орлогыг шингээх хуримтлалын механизм (төрийн сан, баялгийн сан) бий болгох хэрэгтэй. Уг баялгийн санг засгийн газраас хараат төсвийн алдагдлыг нөхөх бус баялгийн орлогыг ирээдүй хойчдоо хадгалж, энэхүү санг **амжилттай хэрэгжүүлж буй орнуудын туршлагыг нэвтрүүлэх** хэрэгтэй.



АНХААРАЛ
ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА




1. Ramos, F. F. R. (2003). Forecasts of market shares from VAR and BVAR models: A comparison of their accuracy. *International Journal of Forecasting*, 19(1), 95–110. [https://doi.org/10.1016/S0169-2070\(01\)00136-1](https://doi.org/10.1016/S0169-2070(01)00136-1)
2. Fisher, B. S., Batdelger, T., Gurney, A., Galindez, R., Begg, M., Bat, . . . Burmaa. (огноо байхгүй). The development of the Oyu Tolgoi copper mine: an assessment of the macroeconomic consequences for Mongolia. Kingston, Australia: School of Economic Studies, National University of Mongolia and BAEconomics Pty Ltd.
3. Ц.Бямбацогт, & Д.Цэнддорж. (2017). Мегатөсөл: Олон улсын туршлага, Монгол Улсын одоогийн нөхцөл байдал, эдийн засагт үзүүлэх нөлөө. Монголбанк
4. Д.Ган-Очир, Л.Даваажаргал (2017). Монголын эдийн засгийн том хэмжээний BVAR загвар: Гадаад шокын нөлөө. Монголбанк
5. А. Ананд (2011). Гадаадын шууд хөрөнгө оруулалтын эдийн засгийн бодит салбарууд дахь нөлөө Монголын жишээ. Монголбанк судалгааны ажил товхимол 6.
- Д. Даваадулам (2018). Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын шинжилгээ. Монголбанк.
7. Ж.Дэлгэрсайхан (2024). Уул уурхайн салбарын гадаадын хөрөнгө оруулалтын Монгол Улсын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө.
8. Б.Ганзориг, Д.Начин. ()Монгол улсын гадаадын хөрөнгө оруулалтын байдал ба шингээх чадавхийн тухай.
9. МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн судалгааны баг. (2018). Оюутолгой төслийн Монголын хөгжилд үзүүлж буй нөлөөллийн судалгаа.
10. Banbura, M., Giannone, D., & Reichlin, L. (2010). Large Bayesian Vector Auto Regressions. *Journal of Applied Econometrics*, 25(1), 71–92. <https://doi.org/10.1002/jae.1137>
11. Batsaikhan, D., & Avralt-Od, P. (2011). Inflation Forecast Error Reduction: Bayesian Vector Autoregression Model (BVAR). *Bank of Mongolia Research Bulletin*, No. 24.
12. Cross, J. L., Hou, C., & Aubrey, A. (2020). Macroeconomic forecasting with large Bayesian VARs: Global-local priors and the illusion of sparsity. *International Journal of Forecasting*, 36(3), 899–915. <https://doi.org/10.1016/j.ijforecast.2020.02.003>
13. Crump, R. K., Eusepi, S., Giannone, D., Qian, E., & Sbordone, A. M. (2021). A Large Bayesian VAR of the U.S. Economy. *International Journal of Central Banking*. (Forthcoming).
14. Koop, G., & Korobilis, D. (2010). Bayesian multivariate time series methods for empirical macroeconomics. *Foundations and Trends® in Econometrics*, 3(4), 267–358. <https://doi.org/10.1561/08000000013>
15. Litterman, R. B. (1986). Forecasting with Bayesian vector autoregressions: Five years of experience. *Journal of Business & Economic Statistics*, 4(1), 25–38.
16. Sims, C. A., & Zha, T. (1998). Bayesian methods for dynamic multivariate models. *International Economic Review*, 39(4), 949–968. <https://doi.org/10.2307/2527347>
17. Mundell, R. A. (1963). Capital mobility and stabilization policy under fixed and flexible exchange rates. *Canadian Journal of Economics and Political Science*, 29(4), 475–485. <https://doi.org/10.2307/139336>
18. Fleming, J. M. (1962). Domestic financial policies under fixed and under floating exchange rates. *IMF Staff Papers*, 9(3), 369–380. <https://doi.org/10.2307/3866091>
19. Mankiw, N. G. (2019). *Macroeconomics* (10th ed.). Worth Publishers.



ХАВСРАЛТ

№	Код нэр	Хувьсагчийн тодорхойлолт	Нэгж	Тайлбар	Хугацаа	Хувиргалт	adf	Эх сурвалж
1	fdi_d11	ГШХО-ын логарифм	ln	Гадаадын шууд хөрөнгө оруулалтын нийт орж ирсэн урсгал	Q	X-13	s	Монголбанк
2	fiscal_d11	Төсвийн зардал / НДНБ- харьцаа ийн харьцаа		Төсвийн нийт зардлын НДНБ-д эзлэх хувь	Q	X-13	s	Үндэсний статистикийн хороо
3	prate	Бодлогын хүү	%	Монголбанкны бодлогын хүү	M	mean	s	Монголбанк
4	tax_d11	Татварын орлого / харьцаа НДНБ		Засгийн газрын нийт татварын орлогын НДНБ-д эзлэх хувь	Q	X-13	s	Үндэсний статистикийн хороо
5	d_11rgdp	Бодит дотоодын нийт бүтээгдэхүүн	ln(тэрбу м төгрөг)	Монгол Улсын бодит ДНБ, инфляц арилгасан байдлаар (лог)	Q	X-13	s	Үндэсний статистикийн хороо
6	agr_d11	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	ln(тэрбу м төгрөг)	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур салбарын бодит ДНБ, инфляц арилгасан байдлаар (лог)	Q	X-13	non-s	Үндэсний статистикийн хороо
7	mining_d11	Уул уурхай, олборлолт	ln(тэрбу м төгрөг)	Уул уурхайн салбарын бодит ДНБ, инфляц арилгасан байдлаар (лог)	Q	X-13	non-s	Үндэсний статистикийн хороо
8	manif_d11	Боловсруулах үйлдвэрлэл	ln(тэрбу м төгрөг)	Боловсруулах салбарын бодит ДНБ, инфляц арилгасан байдлаар (лог)	Q	X-13	non-s	Үндэсний статистикийн хороо
9	energy_d11	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	ln(тэрбу м төгрөг)	Цахилгаан хий, уур агааржуулалт салбарын бодит ДНБ, инфляц арилгасан байдлаар (лог)	Q	X-13	s	Үндэсний статистикийн хороо
10	build_d11	Барилга	ln(тэрбу м төгрөг)	Барилгын салбарын бодит ДНБ, инфляц арилгасан байдлаар (лог)	Q	X-13	s	Үндэсний статистикийн хороо



ХАВСРАЛТ

11	sale_d11	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, м төгрөг) мотоциклийн засвар, үйлчилгээ	ln(тэрбу Бөөний худалдаа, засварын бодит ДНБ, инфляц арилгасан Q	X-13	s	Үндэсний статистикийн хороо	
12	trans_d11	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	ln(тэрбу Тээвэр агуулахын салбарын бодит ДНБ, инфляц арилгасан Q	X-13	non-s	Үндэсний статистикийн хороо	
13	ict_d11	Мэдээлэл, холбоо	ln(тэрбу Мэдээлэл холбооны салбарын бодит ДНБ, инфляц арилгасан Q	X-13	non-s	Үндэсний статистикийн хороо	
14	other_d11	Үйлчилгээний бусад ажиллагаа	ln(тэрбу Үйлчилгээний бусад салбарын бодит ДНБ, инфляц арилгасан Q	X-13	non-s	Үндэсний статистикийн хороо	
15	cri	Хэрэглээний үнийн индекс (ХҮИ)-ийн логарифм	ln(индекс) Монгол Улсын хэрэглээний үнийн индексийн өсөлт (лог)	M	last	s	Үндэсний статистикийн хороо
16	unemp_d11	Ажилгүйдэл	% Эдийн засгийн идэвхтэй хүн амд эзлэх ажилгүй байгаа хүний эзлэх хувь	Q	X-13	s	Үндэсний статистикийн хороо
17	wage	Улсын дундаж цалингийн өсөлтийн хувь	ln(мян.тө Нэг ажиллагчын сарын дундаж цалингийн өсөлт (лог)	M	mean	s	Үндэсний статистикийн хороо
18	m2	M2 мөнгөний нийлүүлэлтийн хувь	ln(тэрбу Мөнгөний нийлүүлэлтийн хэмжээ (лог)	Q	X-13	s	Монголбанк
19	lrate	Зээлийн хүү	% Арилжааны банкуудын дундаж зээлийн хүү	M	mean	s	Монголбанк
20	px	Цэвэр экспорт	жилийн Экспорт импортын зөрүү өөрчлөлт	M	mean	s	Үндэсний статистикийн хороо
21	peer	Нэрлэсэн ханшийн индекс	жигнэсэн ln(индекс) Гадаад худалдааны түнш орнуудын валюттай харьцах төгрөгийн ханшийн индексийн жигнэсэн дундажтай харьцуулсан үнэ	M	mean	non-s	Үндэсний статистикийн хороо

Таамаглал 1. ГШХО огцом нэмэгдсэнээр Голланд өвчин (Dutch disease) бий болох эрсдэлтэй. Оюу Толгойн төслийн үр дүнд Монголын ДНБ 36.4%-иар өсөж, бодит цалин 30%-иар нэмэгдэж, экспортыг 55%-аар өсгөсөн ч төслийн үр дүнд мөн төгрөгийн бодит ханш чангарч, уул уурхайн бус салбарын өрсөлдөх чадвар суларч болзошгүй эрсдлийг тодотгож байв. Fisher (2011)

Таамаглал 2. ГШХО орж ирснээр эдийн засагт өсөлт бий болгож, ажлын байрыг нэмэгдүүлнэ. Уул уурхайн салбар 2023 онд Монгол Улсад орж ирсэн нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтын 75 хувийг эзэлж байна. 2014-2017 онуудад Оюутолгой төсөл хэрэгжсэнээр БДНБ-ыг 9.4 хувиар нэмэгдүүлж, 28000 ажлын байр шинээр буй болсон. (МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн судалгааны баг 2018)

ГШХО 1% ↑


БДНБ 0.76% ↑

Ажиллах хүч 1% ↑

СЭЗИС-ийн судалгааны баг

МОНГОЛ УЛСАД ОРСОН ГАДААДЫН ШУУД
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЛДЭГДЭЛ, эдийн засгийн
ү/а-ны салбараар





ОНОЛЫН ХЭСЭГ


Манделл-Флемингийн жижиг, нээлттэй эдийн засгийн загвар

IS муруй: $Y = C(Y - T) + I(r) + G + NX$

Валютын ханш, e
(а) Цэвэр экспорт





2. Цэвэр экспортыг бууруулна



4. Орлого буурна.




Валютын ханш, e
(в) IS муруй



ОНОЛЫН ХЭСЭГ

Манделл-Флемингийн жижиг, нээлттэй эдийн засгийн загвар

LM муруй: $M/P = L(r, Y)$





МЕГА ТӨСЛҮҮД /ЗГҮАХ-ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО/

БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ – ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО – ХҮНИЙ ХӨГЖИЛ – ЗАСАГЛАЛ

*УРЬДЧИЛСАН ТООЦООЛЛООР, ЭЗХЯ

№	ТӨСЛИЙН НЭР	ХУГАЦАА	НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ* /тб төгрөг/	БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ						2024 /тб төг/	2025* /тб төг/
				УЛСЫН ТӨСӨВ	ГАДААД ЗЭЭЛ	ОРОН НУТАГ	ТХХТ	ТӨК	ХУВИЙН ХЭВШИЛ		
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО			36,960.8	128.8	6,006.9	0.0	8,600.0	2,938.5	18,181.3	516.5	1,337.8
1	“ГАСУУНСУХАЙТ-ГАНЦМОД”, “ХАНГИ-МАНДАЛ”, “ШИВЭЭХҮРЭН-СЭХЭЭ” ХИЛИЙН БООМТУУДЫН ХИЛ ДАМНАСАН ХОЛБОЛТЫН ТӨМӨР ЗАМ, АЧАА ТЭЭВРИЙН ШИЛЖҮҮЛЭН АЧИХ ТЕРМИНАЛ	2024-2028	957.6					957.6			95.7
2	ТАВАНТОЛГОЙН 450 МВТ-ЫН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ	2024-2028	2,303.0					690.9	1,612.1		460.6
3	ЭРДЭНЭБҮРЭНГИЙН 90 МВТ-ЫН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ	2021-2028	855.9		855.9					256.8	100.0
4	ЭГИЙН ГОЛЫН 310 МВТ-ЫН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ	2024-2032	3,700.0				3,700.0				
5	СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ БА ТАРХМАЛ ЭХ ҮҮСВЭР	2024-2028	1,377.0	60.0	211.6					20.0	20.0
6	ХЭРЛЭН-ТООНО, ОРХОН-ОНГИ УС ДАМЖУУЛАХ ШУГАМ	2020-2028	4,900.0				4,900.0				
7	ЭРЭЭНЦАВ-ЧОЙБАЛСАН-БАРУУН УРТ-БИЧИГТ ЧИГЛЭЛИЙН БОСОО ТЭНХЛЭГИЙН АВТО ЗАМ										
8	МОНГОЛ-ФРАНЦЫН ХАМТАРСАН УРАН, АТОМЫН ЦАХИЛГААН СТАНЦ	2024-2028	1,700.0						1,700.0		
9	НҮҮРС-ХИМИ, КОКС-ХИМИЙН ЦОГЦОЛБОР	2025-	12,133.2						12,133.2		
10	ЗЭС БОЛОВСРУУЛАХ ЦОГЦОЛБОР		2,579.9					1,290.0	1,290.0		
11	ГАНГИЙН ҮЙЛДВЭР	2025-2028	1,446.0						1,446.0		
12	ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ЦОГЦОЛБОР	2016-2027	4,178.8		4,178.8					170.9	449.9
13	ОЮУ ТОЛГОЙ ТӨСӨЛД ТҮШИГЛЭСЭН АЛТ ЦЭВЭРШҮҮЛЭХ ҮЙЛДВЭР										
14	ҮНДЭСНИЙ ХИЙМЭЛ ДАГУУЛ	2024-2027	829.4	68.8	760.6					68.8	211.6